

Монголын Эрчим хүч, геологи, уул уурхайн ҮЭ-ийн холбооны Тэргүүлэгчдийн хурлын 2017 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 29 тоот тогтоолоор батлав.

МОНГОЛЫН ЭРЧИМ ХҮЧ, ГЕОЛОГИ, УУЛ УУРХАЙН ҮЭ-ИЙН ХОЛБООНЫ АХМАДЫН ХОРООНЫ ДҮРЭМ

Нэг. Ерөнхий зүйл

- 1.1 МЭХГУУ-н ҮЭ-ийн Холбооны харъяа ҮЭ-ийн хороонд ҮЭ-ийн хорооны даргын сонгуульт ажлыг хийж байсан, ҮЭ-ийн холбооны ажлын албанд ажиллаж байсан ахмадуудыг нэгтгэсэн, тэдэнд үйлчилдэг ашгийн бус олон нийтийн байгууллага.
- 1.2 Ахмадын хорооны оноосон нэр: Монголын Эрчим хүч, Геологи, Уул уурхайн ҮЭ-ийн Холбооны дэргэдэх ахмадын хороо
- 1.3 Ахмадын хорооны албан ёсны хаяг: Улаанбаатар хот Чингэлтэй дүүрэг 1-р хороо Сүхбаатарын талбай МҮЭ-ийн Холбооны төв байр 201 тоот утас 976-11-321230
- 1.4 Ахмадын хороо нь: Өөрийн холбоонд нэгдсэн ахмадуудын хууль ёсны эрх ашгийг хамгаалж, ахмад настанд үзүүлэх хангамж үйлчилгээний тухай Монгол Улсын хуулийн заалтыг хэрэгжүүлэх.
- 1.5 Өөрийн гишүүн ахмадуудын нийгмийн хамгаалал, эрүүл мэндийг хамгаалахад дэмжлэг тусалцаа үзүүлэх
- 1.6 Монгол Улсын эрчим хүч, геологи, уул уурхайн салбарыг хөгжүүлэх талаар төрөөс явуулж байгаа бодлогод ахмадуудын санаа, зөвлөмжүүдийг тусгуулах
- 1.7 Ахмадуудын ажлын баялаг туршлага, Монгол ёс зашлыг залуу үеийнхэнд өвлүүлэх, ахмад, залуу үеийн холбоог бэхжүүлэх ажлыг зохион байгуулах.

Хоёр. Гишүүнчлэл

- 2.1 Энэ дүрмийг хүлээн зөвшөөрч МЭХГУУ-н ҮЭ-ийн Холбооны харъяа ҮЭ-ийн хороонд ҮЭ-ийн хорооны орон тооны даргын сонгуульт ажлыг 5-аас доошгүй жил хийж ҮЭ-ийн байгууллагаас тэтгэвэрт гарсан, ҮЭ-ийн холбооны ажлын албанд ажиллаж байгаад өндөр насны тэтгэвэрт гарсан ахмадууд, хөдөө орон нутгаас УБ хотод шилжиж ирсэн ахмадууд нь тус холбооны гишүүн байж болно. Холбогдох бичиг баримттайгаа ирж ахмадын хороон даргад бүртгүүлснээр гишүүн болно.
- 2.1 Ахмадын хорооны гишүүд хороондоо хандив өгч болно

Гурав. Хорооны удирдлага зохион байгуулалт

- 3.1 Ахмадын хорооны эрх барих дээд байгууллага нь бүх гишүүдийн хурал байна. хурлыг жилд нэгээс доошгүй удаа хийнэ. Гишүүдийн олонхийн саналаар хурлыг хуралдуулж болно.
- 3.2 Гишүүдийн хурлын хооронд хороог ахмадын хорооны дарга удирдана. Хорооны даргыг бүх гишүүдийн хурлаас сонгоно. Хорооны даргад жилд нэг удаа салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний урамшуулал олгож болно.

Дөрөв. Гишүүний эрх, үүрэг

- 4.1 Гишүүний эрх

- Өөрийн үзэл бодлыг чөлөөтэй илэрхийлж, санал шүүмжлэл гаргах
- Ахмадын хорооны даргыг сонгох, даргад сонгогдох
- Хорооны гишүүнчлэлээс татгалзах

4.2 Гишүүний үүрэг

- Хорооны үйл ажиллагаанд идэвхтэй оролцох

Тав. Хороог татан буулгах

5.1 Хорооны гишүүдийн санаачилгаар энэхүү дүрэмд заасан зорилгоо биелүүлсэн гэж үзвэл, ҮЭ-ийн холбооны үйл ажиллагаа зогсож өөр байгууллагатай нэгдсэн болон бусад үндэслэлээр татан буугдаж болно.

---oOo---